



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын
“Хангай” цогцолбор сургуулийг бүтцийн
өөрчлөлтөд оруулах асуудлыг судлах
Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3, 31.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Нийслэлийн ерөнхий боловсролын “Хангай” цогцолбор сургуулийг холбогдох дүрэм, журам, стандартад нийцүүлэн бүтцийн өөрчлөлтөд оруулах асуудлыг судалж санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн гишүүдийг удирдлага, арга зүйгээр хангаж, тус цогцолбор сургуулийг бүтцийн өөрчлөлтөд оруулах үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон тооцоо судалгааг гаргаж холбогдох байгууллагад уламжилж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-д даалгасугай.


3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн А/161 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 01 дүгээр сарын 03 ны өдрийн
1109 дугаар захирамжийн хавсралт



НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН "ХАНГАЙ" ЦОГЦОЛБОР
СУРГУУЛИЙГ БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТӨД ОРУУЛАХ АСУУДЛЫГ СУДЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Б.Болормаа	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Гишүүд:	М.Давааням	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга (зөвшилцсөнөөр)
	Б.Отгонжаргал	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Б.Цогжавхлан	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Э.Соёмбобат	"Хангай" цогцолбор сургуулийн захирал
Нарийн бичиг:	Д.Ундрал	Статистикч
	Ш.Баасансүрэн	Боловсролын хэлтсийн дарга